



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 656

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалт, Баян-Өлгий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 81 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баян-Өлгий аймгийн өмчөөс шилжүүлсэн нийт 287,693,166.67 /хоёр зуун наян долоон сая зургаан зуун ерэн гурван мянга нэг зуун жаран зургаан төгрөг жаран долоон мөнгө/ төгрөгийн балансын үнэ, 8,128,878.46 /найман сая нэг зуун хорин найман мянга найман зуун далан найман төгрөг дөчин зургаан мөнгө / төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын дарга М.Мөнхбат дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.3. Хавсралтад заасан газар эзэмших эрхийг Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын нэр дээр баталгаажуулах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



13201408

Төрийн өмчийн боллого зохицуулалтын газрын  
 2020 оны 12 дугаар сарын 14 өдрийн  
 656 дугаар тогтоолын хавсралт

Баян-Өлгий аймгийн өмчөөс төрийн өмчид хүлээн авч Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газарт  
 эзэмшүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Хэмжээ	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элдэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/
1	Цэнгэл сумын сум дундын эмнэлэгийн А-блокон барилга	1979.01.01	м.кв	714	201,775,455.37	8,071,018.21	193,704,437.16
2	Цэнгэл сумын сум дундын эмнэлэгийн А-блокон барилгын газар эзэмших эрх	1979.01.01	м.кв	2999	5,988,000.00		
3	Цэнгэл суманд байрлах Автомашины граж	2019.01.01	м.кв	120	75,000,000.00		
4	Дэлүүн сумын Сум дундын эмнэлэгийн амаржих байр	1978.01.01	м.кв	60	2,603,711.30	57,860.25	2,545,851.05
5	Дэлүүн сумын Сум дундын эмнэлэгийн амаржих байрны газар эзэмших эрх	1978.01.01	м.кв	1163	2,326,000.00		
					287,693,166.67	8,128,878.46	196,250,288.21
	Нийт дүн				/хоёр зуун наян долоон сая зургаан зуун ерэн гурван мянга нэг зуун жаран зургаан төгрөг жаран долоон мөнгө/	/найман сая нэг зуун хорин найман мянга найман зуун далан найман төгрөг дөчин зургаан мөнгө/	/нэг зуун ерэн зургаан сая хоёр зуун тавин мянга хоёр зуун наян найман төгрөг хорин нэгэн мөнгө/